

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ОНОЛ-АРГА ЗҮЙН АСУУДАЛД****С.Базарпүрэв** доктор, профессор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим

**Товч агуулга:** Улс орны гадаад, дотоод нөхцөл байдалд их өөрчлөлт гарч “хүйтэн дайны” үед “хялбар” ажилтай байсан, “бусдад” даатгасан хамгаалалтын тогтолцоо нь орчин үеийн бодит нийгмийн хэрэгцээг хангах чадваргүй гэдэг нь харагдаж, олон улсын болон үндэсний аюулгүй байдлыг бүрдүүлэх системийн бүтцийг шинэчлэн зохион байгуулах асуудалд анхаарах цаг хэдийнээ болсон байна.

**Түлхүүр үг:** Үндэсний аюулгүй байдал, Даяаршил, Үндэстний ижилсэлт, Үндэсний сонирхол, Үндэсний аюулгүй байдлыг хангах улс төрийн бодлого

XX зууны 90-д оны эхээр Монгол орны улс төрийн систем эрс өөрчлөгдөж, бүрэлдэн тогтсон нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал олон улсын харилцаанд нээлттэй, чөлөөтэй оролцох боломжийг нээж өгсөн. Зуун дамнан дэлхий нийтэд өрнөсөн даяарших үйл явц ч үүнд их хувь нэмэр болж байна. [“XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграц өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт үеийнхээс эрс өөрчлөгдлөө. Хөгжлийн шинэ томоохон төвүүд тодорч, олон улсын харилцаанд тэдгээрийн үзүүлэх нөлөө өсөх хандлагатай байна” (“Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал батлах тухай” МУИХ-ын тогтоол 2011 оны 02 дугаар сарын 10 өдөр № 10)].

Өнөөдөр дэлхийн олон орон түүний дотор улс төрийн систем нь бүрэн солигдсон төдийгүй мөн хөгжилтэй улс орны төр засаг ч гадаад бодлого, үндэсний ба олон улсын аюулгүй байдлын номлолоо эргэж харан шинэчлэх бодит шаардлага гарсан гэдгийг хүлээн зөвшөөрч хэтийн ба ойрын улс төрийн бодлого боловсруулах ажил өрнүүлж байна.

Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, батлан хамгаалах салбарт хэрэгжүүлэх төрийн бодлогоо тодорхойлох үйл ажиллагаа Монголд ч идэвхтэй хийгдэж байна. [“Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн” (“Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал батлах тухай” МУИХ-ын тогтоол 2011 оны 02 дугаар сарын 10 өдөр № 10)].

Ийм хэрэгцээ байгаа нь бодит байдал, өөрчлөгдсөн гадаад дотоод нөхцөлтэй холбоотой юм.

Улс орны хөгжлын асуудлыг дангаараа өөрсдөө хариуцах болсон эдүгээ цагт үндэсний аюулгүй байдлаа хангах зорилго, зорилтууд Монгол улсын, улс төрийн эрх мэдэл бүхий этгээд, төрийн институтын өмнө тулгараад байна. [“Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Засгийн газар, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ” (“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” МУИХ-ын тогтоол, 2010 оны 07 сарын 15 өдөр дугаар 48, 4.2.1)].

Улс орны гадаад, дотоод нөхцөл байдалд их өөрчлөлт гарч “хүйтэн дайны” үед “хялбар” ажилтай байсан, “бусдад” даатгасан хамгаалалтын тогтолцоо нь орчин

үеийн бодит нийгмийн хэрэгцээг хангах чадваргүй гэдэг нь харагдаж, олон улсын болон үндэсний аюулгүй байдлыг бүрдүүлэх системийн бүтцийг шинэчлэн зохион байгуулах асуудалд анхаарах цаг хэдийнээ болсон байна.

XX зуунд сайн танигдаагүй байсан нийгэм, улс төрийн үзэгдлүүд өнөөдөр улс орны амьдралд хүч түрэн, хурдацтай нөлөөлөх болсон.

Даяаршил эрчимтэй өрнөж, үндэстний ижилслийн хямрал газар авч, үндэстэн дамнасан алан хядлага-терроризм дэлхийг нөмөрч, исламын "дарамт" нүүрлэн, олон улсын байгууллага, НҮБ-ын үйл ажиллагаа явуулах чадвар доройтсон нь нэгэнт ил тод болжээ.

Дээрх үзэгдэл үндэсний аюулгүй байдалд шууд хамааралтай учир аюулгүй байдлын онол, арга зүйн байр суурийг эргэж харах, түүнийг хангах нөөц, арга хэрэгслийг шинэчлэн тогтоох, үндэсний сонирхлыг зохистой томъёолж, нэгтгэх, дотоод, гадаад улс төрийн бодлогын алийг нь түлхүү тавьж, урьтал болгох талаар тодруулга хийх нь нэн тулгамдсан асуудал юм.

Үндэстний ижилслийн асуудалтай нягт уялдан аюулгүй байдлын талаарх улс төрийн бодлого бүрэлдэн төлөвших учиртай юм. Мөн хөгжлийн үндэсний стратегийг тодорхойлж, даяаршлын үйл явцыг харгалзан аюулгүй байдлын номлолыг боловсруулах болж байна.

Ардчилах, эдийн засгийн ойртон нягтралт, мэдээлэлжүүлэх, соёлын нэг хэв шинжинд оруулах, үнэт зүйлийг нийтэд хэвшүүлэх нь үндэсний аюулгүй байдалд үлэмж нөлөөтэй даяаршлын тодорхой үйл явцууд юм. Эдгээр үйл явц үндэсний ижилсэлтэй зайлшгүй тулгарч олон зуун жилийн туршид бүрэлдэн тогтсон үндэстэн ястны соёл, уламжлал, үндэстэний өөрийн талаарх тогтсон төсөөлөлийг эвдэх "аюул" учруулдаг байна.

Тухайн "аюулыг" үндэсний сонирхолд ашигтай нийцүүлэн зохицуулах явдал нь үндэсний аюулгүй байдлыг хангах нэн тэргүүний зорилго болоод байна. Үндэстний ижилсэлт нь үндэсний аюулгүй байдлыг хангах чухал үндэс мөн бөгөөд даяаршлын нөхцөлд улс орны өрсөлдөх чадварын нэг гол нөөц болдог байна.

ЗСБНХУ, Югослав, Чехословак зэрэг улс орон өрсөлдөх чадвар нь шавхагдаж, задарч унасан түүхтэй. Өнөөдөр ч гэсэн үндэстний ижилслээ алдах аюул олон оронд тулгараад байна. Даяаршил уг үйл явцыг хэрэгжүүлэхийг эрмэлзэж байхад улс орон өөрийн соёл, уламжлалаа хадгалж үлдэх гэж тэмцэж байна.

Үндэстний ижилслээ алдсанаар үндэстний үнэт зүйлсийн баримжаа баларч, төр улс бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болж улмаар үндэсний сонирхлоо "гээж", бие даасан гадаад, дотоод бодлого явуулах чадваргүй болдог байна. Улс төрийн янз бүрийн сонирхлууд нийгэмд зэрэгцэн оршиж зөрчилдөх, зарим тохиолдолд өөрийн хүсэл зорилго, сонирхлоо тодорхойлж чадахгүй байх, мөн эдийн засгийн нөөц боломж, санхүүгийн хомсдол нь үндэстний ижилсэлд сөрөг нөлөөтэй юм. Харин үндэсний ижилслийг зүй зохистой, оновчтой томъёолж, түүнд тулгуурлан үндэсний сонирхлоо цэгцтэй тодорхойлсоноор хараат бус гадаад, дотоод бодлого явуулах боломж нээгддэг. ["Нийгмийн ёс суртахуун, сэтгэл зүйн төлөвшил, үнэт зүйлсийн нэгдмэл байдлыг хангах нь үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, зөвшилцлийг хангах суурь болно" ("Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай" МУИХ-ын тогтоол, 2010 оны 07 сарын 15 өдөр дугаар 48, 3.3.3.1)].

Улс төрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадвараа алдаж, бусдын эрхшээлд орсон ч гэсэн үндэстний ижилслээ сэргээн тогтоох талаар хүч чармайлт тавьж түүний төлөө идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлж чадвал тусгаар тогтнолоо буцаан

олж авч чадна. Соёл, уламжлал, түүх, улс төр хүчийг агуулж байж даяаршлын үйл явцад уусахгүй үлдэж болно.

Даяаршлыг "мунхаглан" эсэргүүцэх боломжгүй юм. Даяаршлын үйл явц ашиг гаргах боломжийг олгодог түүнийг алдахгүй байж аялдан дагагчийн байр суурийг орхин өөрсдөө идэвх гаргаж тоглоомын дүрэм зохиолцох хэрэгтэй юм. Даяаршлын субъект нь их гүрэн улс байдаг ч өнөөдөр дэлхийн улс орон бүр уг үйл ажиллагаанд бүтээлчээр оролцох бололцоотой билээ.

Орчин үеийн ертөнцийг ардчилах үйл явц даяаршлын нэг тодорхой илрэл юм. Гадаад, дотоод бодлоготоо нийтлэг дүрмэнд захирагдах шаардлага тулгаж, нийгмийн үндсэн эд эсийн байрыг сольж өөрчилж байна. Юуны өмнө, бие хүнийг дараа нь нийгмийг тэгээд төрийг тавих болжээ. Төр хүн, нийгмийн сонирхлыг хамгаалах гол хэрэгсэл хэмээн үзсэн. ["Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарна" ("Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай" МУИХ-ын тогтоол, 2010 оны 07 сарын 15 өдөр дугаар 48, 1.2.2)]. Дээр дурдсан шатлалыг хатуу мөрдсөн тохиолдолд олон улсын тавцанд ямар нэгэн байр суурь эзэлж, амжилт гаргах боломжтой юм. Орчин үед өрнөж буй ардчилах үйл явц нь олон улсын харилцааг өөрчилж, ардчилсан хэм хэмжээг зөрчих үйл ажиллагааг таслан зогсоож, хүний эрх, эрх ашгийг хамгаалж байна. Өнөөдөр дотоод бодлогоосоо хэт өөр гадаад бодлого явуулах, гадаад нөхцөл байдлыг харгалзаж үзэлгүй дотоод бодлого боловсруулан хэрэгжүүлэх боломжгүй болжээ. Даяаршлын ардчилах үйл явц үндэстний ижилслийн тогтолцоонд хатуу хязгаар тогтоож байна.

Олон улсын тавцанд эдийн засгийн салбарт ойртон нягтрах үйл явц эрчимтэй явагдаж, нэгдсэн орон зай төлөвшиж түүнд олон орон татагдан орж байна. Орчин үед салан тусгаарлах байр суурь нь үндэсний аюулгүй байдал, үндэсний хөгжлийн загварыг ирээдүйгүй болгож харин ойртон нягтрах нь үндэстний сонирхлыг хамгаалах үр ашигтай арга болон хувирч байна. Эдийн засгийн хувьд ойртон нягтрах нь хөгжлийн эх сурвалж болж үндэсний аюулгүй байдлыг хангах урьдчилсан нөхцөл болдог.

Дэлхийн эдийн засгийн орон зайд багтан "хэрэгцээтэй" нэг хэсэг нь болоогүй цагт өрсөлдөх чадвар суухгүй ажээ. Гео эдийн засгийн арга хэрэгсэл үндэсний аюулгүй байдлыг хангах гол хүчин зүйл болж байна. Зарим тохиолдолд эдийн засгийн ойртон нягтрал үндэстний ижилсэлд сөрөг нөлөө үзүүлдэгийг тэмдэглэх нь зүйтэй.

Мэдээлжүүлэх үйл явц нэгдсэн мэдэллийн орон зайг төлөвшүүлэн глобал сүлжээг бүрдүүлж түүнд хамрагдсан бүхэн материалаг баялаг хүртэх боломжийг нээж, оюуны нөөцийг үржүүлэн нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийг ханган эерэг үр дүнд хүргэдэг байна. Нөгөө талаас мэдээллийн технолог сөрөг талыг өөртөө агуулдаг. Олон нийтийн санаа бодлыг хянаж түүгээр тоглож, удирдах шинэ эх сурвалж, сувгийг нээж мөн иргэдийн үзэл санаа, ухамсарт нөлөөлөх үр бүтээлтэй шинэ хэрэгслийг бүтээсээр байна. Энэ бүгд нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд шинэ чиг хандлага нэмж байна гэсэн үг юм. Глобал шинжтэй мэдээллийн урсгал ижилслийг үгүй хийх нэг хүч болж байна. Мэдээлэл нээлттэй болсоны үр дүнд соёлын нэг хэв шинжинд орох үйл явц идэвхжсэн. Төрөл бүрийн соёлыг зааглаж байсан хаалт үгүй болж соёлын ижилсэл задарсан байна. Эрчимтэй өөрчлөгдөж буй бодит байдалд дасан зохицох шаардлага улс орны өмнө тулгарсан. Үндэсний өвөрмөц онцлогийг хадгалан орчин үеийн соёл иргэншлийн ололтыг эзэмших хэрэгцээ ч гарч байна.

Гэвч энэ тэнцвэргүй “тулаанд” улс орон амжилт гаргах найдвар бага юм. Их Британи, Герман, Франц зэрэг хөгжилтэй улс орон ч даяаршлын түрлэгт өртөж, үндэсний аюулгүй байдлын асуудалд анхаарал тавих болжээ.

Үнэт зүйлсийг нийтэд хэвшүүлэх үйл явцыг даяаршил хэрэгжүүлж байдаг. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр барууны үнэт зүйл хэмээгдэх хүний эрх, эрх чөлөө, ардчилал, чөлөөт зах зээлтэй эдийн засаг, эрх зүйт төр, иргэний нийгмийг сурталчилан барууны хөгжлийн загварын давуу тал гэдгийг ухуулах болжээ. Дээрх үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, дагаж мөрдсөн улс орон тодорхой амжилтанд хүрсэн байна. Гэсэн ч эдгээр үнэт зүйлс нь мөнх бус, барууны соёлын үе өнгөрч өөр үнэт зүйлс гарч ирж ноёлох боломж нээлттэй билээ.

Өнөөдөр даяаршил нийгэм эдийн засаг, технологийн хувьд хөгжсөн улс орны эрх ашигт илүү нийцэж байна. Үүнээс үүдэн баян ядуу орны хооронд зөрчил үүсэж мөргөлдөөнд хүргэх аюул бий болсон ажээ.

Даяарших үйл явц үндэсний соёл, иргэншлийг доройтуулж байгаа ч нөгөө талаас өөрийгөө ухаж ойлгох үндэсний ухамсрыг дээшлүүлж байгааг тэмдэглэх хэрэгтэй юм. Даяаршил улс оронд хөгжих шинэ боломж гаргаж, шинэ аюулыг давхар бий болгож байна. [“Даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхлоо хамгаалж бататгах боломж олгож байна” (“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” МУИХ-ын тогтоол, 2010 оны 07 сарын 15 өдөр дугаар 48, 1.2.6)].

Орчин үед даяаршлын үйл явцыг АНУ манлайлж, дэлхийн тавцанд тогтож буй дэг журмыг хөгжилтэй улс орон тогтоож байна. Олон улсын аюулгүй байдлын асуудлыг эдгээр орон үндсэндээ шийдвэрлэдэг.

Үндэсний сонирхлыг хамгаалан, үнэт зүйлийг аривжуулахад чиглэсэн төр, нийгэм, иргэдийн үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдлын улс төрийн бодлого хэмээн үздэг. Өнөөдөр үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал зөвхөн аюулаас хамгаалах гэсэн утга санааг агуулдаггүй. Үндэсний аюулгүй байдлыг хангах гэдэг нь тогтвортой ардчилсан хөгжлийн салшгүй нэг хэсэг төдийгүй мөн түүний хэрэгжилтийг хангах гол нөхцөл болоод байна.

Үндэсний аюулгүй байдлын талаар баримтлах улс төрийн бодлого нь аюулыг зайлуулах үйл ажиллагаа явуулахаас гадна хүний эрх, эрх чөлөө, нийгмийн үнэт зүйлс, үндсэн хуульт байгуулал, тусгаар тогтнол, төр улсын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг бэхжүүлэн, хөгжүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажилтай болоод байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах улс төрийн бодлого нь шинжилгээ судалгаан дээр тулгуурласан урт хугацааны байдаг ч тодорхой богино хугацаанд нягтлагдан тодруулга, “тохиргоо” хийгдэж байх нь нэн чухал. Тухайлбал, уг асуудлаар АНУ-д 10-15 жилийн хугацаанд баримтлах стратегийн бодлого боловсруулан мөрддөг. Дээрх бодлого төрийн албан ёсны шинж чанаргүй. Дөрвөн жилд нэг удаа үндэсний аюулгүйн бодлогоор АНУ-ын засаг захиргаа илтгэл сонсгодог байна. Үндэсний аюулгүй байдлыг хангах улс төрийн бодлогыг үндэслэх арга зүйн асуудлыг орчин үеийн шинжлэх ухааны ололтыг ашиглан шинэчлэн боловсруулах шаардлага ямагт байдаг.

“Аюулгүй байдлыг хангах” асуудалтай холбогдон бие хүний амь амьдрал, үйл ажиллагаанд заналхийлэл учрахаас авахуулаад глобал сүйрлийн аюул нүүрлэх зэрэг төрөл бүрийн сөрөг үзэгдлийг авч үзэх хэрэгцээ урган гарч байна.

Жирийн иргэн, хууль сахиулах байгууллага, аюулгүй байдлыг хангах салбарын судлаач эрдэмтэн, төрийн тэргүүн гэх мэт олон янзын байр сууринаас үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг авч үзэж болно.

Орчин үед үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар хоёр хандлага зэрэгцэн оршиж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Нэгд, бодит хандлага. Гадаад орчноос аюулын хэмжээг тодорхойлон үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг боловсруулан шийдэх. Үүнтэй уялдан аюулгүй байдлыг хангах зорилгоор гадаад орчинг “өөрчлөх” үйл ажиллагааг хэрэгжүүлж, уг орчинд байгаа бодит аюулын эх сурвалжид хаалт хийж түүнийг үгүй хийх зорилт тавьдаг. Хоёрт, үйл ажиллагааны хандлага. Энэ хандлага нь үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг төр болон бидний дотоод үйл ажиллагаатай холбон, аюулын эх сурвалжийг, аюулд учирч буй объектой нэгтгэн авч үздэг байна.

Системийн онол, арга зүй нь аюулыг байгалийн үйл явц ч юм уу аль эсхүл гаднаас заналхийлэх давуу хүчтэй холбон авч үзэлгүй нийгмийн дотоод хүчин зүйлтэй уялдуулах нь илүү ашигтай, үр бүтээлтэй гэж үздэг. Аливаа аюулын эх сурвалж нь бид өөрсдөө. Буруутай, мэдлэггүй, урвуулан тэрсэлсэн үйлдлээс аюул нүүрлэх нь тун элбэг учир нийгмийг бүхэлд нь хариуцсан төр засгийн хүч, чадавхи үүнийг “төлөвшүүлэхгүй” байх санхүү, түүхийн эдийн ба хүний нөөцтэй байх нь нэн чухал ба түүнийг арившуулан, хомсдлыг арилгах ёстой юм.

Төрийн засгийн эрхийг барьж буй улс төрийн хүч үндэсний аюулгүй байдлыг шууд хариуцах ёстойг тэмдэглэхийн зэрэгцээ иргэн ч өөртөө аюул учруулахгүй байх нөхцлийг бүрдүүлэхэд үлэмж их үүрэгтэй. [“Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа” гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх тал бүрийн баталгаа бий болгоход чиглэсэн төрийн бодлогыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ. (“Үндэсний аюулгүй байдлын тухай” МУХ, 2011 оны 12 дугаар сарын 27)]

Аюул нь юуны өмнө хүн түүний өмч хөрөнгө, цаашилбал нийгэм, төр улс, соёл иргэншилд заналхийлдэг ба тухайн аюулыг хүмүүн төрөлхтөн, нийгэм өөрөө бүтээдэг. Шинжлэх ухааны дэвшил нь хүнд заналхийлэх аюулыг бий болгодог. Үүнээс үүдэн хүнийг аюулаас хамгаалах номлолын ач холбогдол өссөж, бодитой тулгарч болох аюултай үйл явцыг судлан түүнийг урьдчилан тооцож, түүнээс хамгаалах арга хэмжээг санал болгож, үйл ажилгааны удирдамж боловсруулах нь нэн чухал юм.

Уг аюултай “ажиллах” арга барил, зохион байгуулалтын хэлбэр, арга хэрэгсэл, бидэнд байх, байхгүй гэдгээс аюулыг зайлуулах үйл явц шууд хамааралтай юм. Тиймээс аюулыг иж бүрэн шинжлэж түүний талаар бүрэн төгс мэдлэг, мэдээлэлтэй байх нь түүнийг удирдан, хянах боломж бүрдэж гэнэтийн гэх зүйл багасах магадлалтай юм.

Ер нь нийгэмд нүүрлэх аюул ямар нэгэн байдлаар тогтмол оршин байдаг. Түүнийг дуудаж өдөөх нь бас л бидний зүй зохисгүй, ухвар мөчид, мэдлэг, чадваргүй үйл ажиллагаатай холбоотойг дахин тэмдэглэмээр байна. Намжмал байгаа аюулыг сэдрээхгүй байж түүнийг аль болох хяналтандаа байлгаж нийгмийн сонирхолд нийцүүлэн удирдан чиглүүлэх нь өнөөгийн төр засгийн бодлогод тулгамдсан асуудал болоод байна.

Дээр дурдсан зүйлээс арга зүйн шинжтэй дүгнэлт хийж болно.

Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдлын асуудлыг зөвхөн засгийн эрх барьж буй улс төрийн хүч, түүний мэдэлд буй төр засаг дангаараа хариуцдаг онцлогтой.
2. Тухайн үүргийг биелүүлэн, гүйцэтгэх явдал нь төр ямар хэмжээний нөөц агуулж ашиглах боломжтой гэдгээс шууд хамаарна.
3. Аюулгүй байдлыг хангах механизмын хувьд уламжлаж ирсэн хэрэгсэл байгаагийн зэрэгцээ “барууны” арга барилд суралцах нь чухал ч Монгол

улсын өнөөгийн нөхцөлд таарч тохирсон аюулгүй байдлыг хангах арга барил, нөөц олж тогтоох нь ач холбогдолтой байна.

4. Үндэсний аюулгүй байдлын асуудал хариуцаж буй мэргэжилтний ур чадвараас гадна төрийн захиргааны зохистой үйлдлээс их зүйл шалтгаалдаг байна. Хараат бус шинжээчдийн санал, зөвлөмжийн гадуур байх нь тэдний зөвхөн алдаа төдийгүй, санаатай гэмээр гажуудалт юм.
5. Үндэстний ижилслийн асуудалтай нягт уялдан аюулгүй байдлын талаарх улс төрийн бодлого бүрэлдэн төлөвшиж, хөгжлийн үндэсний стратегийг тодорхойлж, даяаршлын үйл явцыг харгалзан аюулгүй байдлын номлолыг боловсруулах болж байна.

### Резюме

Внешняя и внутренняя политика государства определяется множеством условий и факторов, среди которых уровень социально-экономического и политико-правового развития, географическое и геополитическое положение страны, ее национально-исторические традиции, цели и потребности, задачи обеспечения государственного суверенитета и национальной безопасности.

### Ном зүй

1. “Үндэсний аюулгүй байдлын тухай” МУХ., 2001 оны 12 дугаар сарын 27-ны өдөр.
2. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” МУИХ-ын тогтоол. 2010 оны 07 сарын 15 өдөр Дугаар 48
3. “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал батлах тухай” МУИХ-ын тогтоол 2011 оны 02 дугаар сарын 10 өдөр № 10